



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийг
байгуулж, зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/ Маргаан таслах зөвлөлийн дарга:

Т. Гандулам	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын дарга
-------------	--

2/ Маргаан таслах зөвлөлийн гишүүд:

Т. Жамбаажамц	Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын орлогч дарга
---------------	--

Б. Энхбат	Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын Үнэт цаасны бодлогын хэлтсийн дарга
-----------	--

Т. Гантулга	Санхүүгийн зохицуулах хорооны Тамгын газрын Эрх зүйн хэлтсийн ахлах референт
-------------	--

Л. Нямдагва	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хяналт шалгалтын албаны захирал /зөвшилцсөнөөр/
-------------	--

Б. Саруул	“Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийн Дотоод хяналтын албаны мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
-----------	--

Г. Алтансүх	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
-------------	---

Д. Дүгэржав	“MDS and Khanlex” ХХН-ийн партнер
-------------	-----------------------------------

Н. Цогт	“Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
---------	--

3/ Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Г. Дөлгөөн

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны
зохицуулалтын газрын Үнэт цаасны бодлогын
хэлтсийн мэргэжилтэн

2. Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг Хорооны
хуралдаанд танилцуулж ажиллахыг Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөл /Т.
Гандулам/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦӨТГЭГЧ
ДЭД ДАРГА  Э.БАТБОЛД

